



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/171

Улаанбаатар хот

┌ Уулзалтад оролцуулах тухай ┐

Харилцаа холбооны зохицуулах хорооны Дүрмийн 3.1.2, 3.1.10 дахь хэсэг, Хөдөлмөрийн дотоод журмын 5.7.1 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны томилолтоор ажиллах журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сингапур болон Малайз Улсын зохицуулах байгууллагуудтай уулзалт хийж, цаашид туршлага судалж хамтран ажиллах талаар санал солилцох, Фэйсбүүк компанийн Сингапур дах Азийн салбарт Монгол Улсыг хариуцан ажиллаж буй холбогдох баг бүрэлдэхүүнтэй уулзах, фэйсбүүк орчинд хийх зарим зохицуулалтын арга хэмжээний талаар ярилцах уулзалтуудад Сингапур болон Куала Лумпур хотноо 2022 оны 05 дугаар сарын 31-нээс 2022 оны 06-р сарын 9-ний өдрүүдэд оролцох баг бүрэлдэхүүнийг томилсугай.
2. Уулзалтын баг бүрэлдэхүүнийг нэгдүгээр, хөтөлбөр, удирдамжийг хоёрдугаар, зардлын төсвийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Шаардагдах зардлын төсвийг холбогдох эх үүсвэрээс олгохыг Санхүүгийн хэлтсийн дарга /Н.Халиунаа/-д зөвшөөрсүгэй.
4. Уулзалтын талаарх тайланг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газарт тайлагнахыг уулзалтад оролцох баг бүрэлдэхүүний ахлагч Д. Ариунболд-д үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус хорооны Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ



Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны
даргын 2022 оны 05 сарын 23 өдрийн
А/17/тоот тушаалын нэгдүгээр хавсралт

Уулзалтад оролцох бүрэлдэхүүн:

Багийн ахлагч:

1. Зах зээл, үнэ тарифын үнэлгээ, судалгааны газрын дарга
Д. Ариунболд;

Гишүүд:

2. Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын, интернэтийн сүлжээ, үйлчилгээний хэлтсийн дарга Т. Батболд;
3. Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн хөгжлийн хэлтсийн дарга Х. Нинжболор;
4. Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын технологийн хөгжлийн төвийн дарга С. Долгорсүрэн;
5. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын зохицуулалтын хэрэгжилтийн хэлтсийн дарга Н. Тогтохсүрэн;
6. Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн П. Золбоо

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны
даргын 2022 оны 05 сарын 25 өдрийн
А/171 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

Уулзалт, арга хэмжээнд оролцох удирдамж

Харилцаа холбооны зохицуулах хорооны баг төлөөлөгчид Сингапур улсад зохион байгуулагдах “Asia Tech 2022” үзэсгэлэн, хуралд оролцох, Сингапур улсын Мэдээлэл, харилцаа холбооны зохицуулах байгууллага (IMDA), Малайз Улсын Харилцаа холбооны зохицуулах байгууллага (MCMC)-тай уулзалт хийж, цаашид туршлага судалж хамтран ажиллах, Фэйсбүүк компанийн Сингапур улс дах Азийн салбарт Монгол Улсыг хариуцан ажиллах буй холбогдох баг бүрэлдэхүүнтэй уулзаж фэйсбүүк орчинд хийх зарим зохицуулалтын арга хэмжээний талаар ярилцаж, санал солилцох уулзалтуудыг Сингапур болон Куала Лумпур хотноо 2022 оны 05 дугаар сарын 29-нөөс 2022 оны 06-р сарын ...-ний өдрүүдэд зохион байгуулна.

Энэхүү уулзалтад оролцох тус хорооны баг бүрэлдэхүүн нь дараах удирдамж, чиглэлийг баримтлан оролцоно. Үүнд:

1. “Asia Tech 2022” үзэсгэлэн хуралд оролцож шинэ дэвшилтэд технологи, дараа үеийн дижитал үйлчилгээтэй танилцах, судлах;
2. Фэйсбүүк компанийн Ази-Номхон далайг хариуцсан Сингапур Улс дах салбарт зочлох, “ногоон суваг”-ийн үйл ажиллагааны талаар уулзалт хийх, хэрэгжилтийг сайжруулах, нийтээр дагаж мөрдөх стандарт (community standards)-ын талаар сургалт авах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
3. Twitter компанийн төлөөлөгчидтэй уулзаж, хамтран ажиллах хүсэлт тавих, албан бичгийг хүргүүлэх;
4. Сингапурын улсын мэдээлэл, харилцаа холбооны зохицуулах байгууллагын (Infocomm Media Development Authority (IMDA)) төлөөлөлтэй уулзаж, шинэ дэвшилтэд үйлчилгээний зохицуулалтын талаар болон цаашид судалгаа хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр туршлага судалж, санал солилцох;
5. Малайз улсын Харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн зохицуулах; байгууллагатай уулзалт хийж дараах хүрээнд туршлага судлах, санал солилцох:
 - Интернэтийн чанарын зохицуулалт, хяналтын үйл ажиллагааны талаар судлах, мониторингийн төвийн үйл ажиллагаа, хяналт хийж буй аргачлал, ашиглаж буй техник технологитой танилцах;
 - Шинэ дэвшилтэд үйлчилгээний талаарх зохицуулалт (mVoIP, OTT-Communicating, SMS Service);

- Клауд үйлчилгээний талаар авч буй зохицуулалт (Шинэ хууль гарсантай холбоотой авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар);
- Шинэ дэвшилтэд технологийн зохицуулалт, түүнд чиглэсэн зохицуулалтын судалгааны үйл ажиллагааны талаар;
- Цахим орчны зохицуулалт (Facebook, Social Media, Online Child Protection);
- Зах зээл, өрсөлдөөн, үнэ тариф, бүх нийтийн үүрэгт үйлчилгээ;
- Апп эдийн засгийг хөгжүүлэх чиглэлээрх зохицуулалт;
- Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлийн өрсөлдөөний байдалд үнэлэлт дүгнэлт өгдөг, энэ талаар судалгаа хийдэг эсэх, тусгай зөвшөөрөл олгохдоо авч үздэг эсэх асуудлаар;
- Радио, телевизийн үйлчилгээний хэт төвлөрлийн зохицуулалтын талаар;
- Радио, телевизийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага, хөтөлбөрт тавих шаардлагын хэрэгжилтэд хэрхэн хяналт тавьж ажилладаг, радио, телевизийн хөтөлбөрт байнгын мониторинг хийдэг эсэх;
- Дижитал платформуудын нөлөөллөөс радио, тв-ийн өргөн нэвтрүүлгийг хамгаалах, өрсөлдөх чадварыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлдэг зохицуулалтын арга хэмжээний талаарх мэдээлэл.
- Судалгаа, сургалт болон зохицуулалтын чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцох, албан хүсэлтийг хүргүүлэх;

Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны
даргын 2022 оны 05 сарын 25 өдрийн
А/А/ тоот тушаалын гуравдугаар хавсралт

УУЛЗАЛТ, АРГА ХЭМЖЭЭНД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2022.05.31 - 2022.06.10

№	Зардлын утга	Төсөвлөсөн US\$/₮	Тайлбар
1	Зам хоног	$(US\$50 \cdot 11) \cdot 6 \text{ хүн} = US\3300	
2	Зочид буудал	$(US\$150 \cdot 10) \cdot 6 \text{ хүн} = US\9000	
3	Тийз	$3'823'000₮ \cdot 6 \text{ хүн} = 22'938'000₮$	
4	Замын зардал	$US\$40 \cdot 6 \text{ хүн} = US\240	Сингапур-Малайз, Малайз - Сингапур
	Нийт дүн:	US\$ 12,540 22' 938'000₮	